

**ОРЧУУЛГЫН ЗОХИОЛЫН НАЙРУУЛГЫН  
УР МАЯГТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ**  
**/А.П.Чеховын “Дугтуйтай хүн” зохиолын жишээн дээр/**

М.Алтанцэцэг  
Г.Нямгэрэл  
/МУИС/

**Товч агуулга:** Уран зохиолын найруулга нь хэлний дүрслэх болон яруу хэрэглүүрийг өргөн ашигладаг, уран дүрийг бүтээдэг, үгсийн сангийн бүхий л нөөцийг хэрэглэх боломжтой байдгаараа бусад найруулгаас ялгардаг. Энэ өгүүллэгт найруулгын ур маяг, зарим алдааг А.П.Чеховын “Дугтуйтай хүн” өгүүллэгийн жишээн дээр авч үзэв.

**Түлхүүр үг:** Үг давталт, үгийн оноолт, хэл зүйн хэлбэржилт, хэм хэмжээ, үг бүтэх ёс, хэмнэлтийн зарчим, үгийн өнгө аяс.

Дэлхий нийтийн сонгодог зохиол бүтээл, түүн дотроос оросын сонгодог бүтээлээс орчуулахдаа уншигчдын оюун санааны хэрэгцээ гоо зүйн боловсролд нөлөөлөхүйц, тэдний сэтгэлийг ямагт догдуулж байдаг нийгэм, улс төр, аж байдлын чухал асуудалд хариу өгсөн, уран бүтээлчдэд бүтээн туурвих, урнаар дүрслэхийн жишээ болсон зохиолыг манайд орчуулан нийтлэх уламжлал нэгэнт тогтжээ.

Үгийг хэчнээн зөв орчуулсан ч хооронд нь холбон найруулж чадахгүй бол өгүүлбэр болохгүй. Аливаа зохиол чухамхүү өгүүлбэрээс бүтэх учир өгүүлбэрийн ур найруулга хэдий чинээ сайтай байна, зохиол төдий чинээ яруу сайхан болох нь мэдээж. “Хэл зүйн утга нь байрлалд шүтэж, байрлал нь холбоход шүтэх тул бүтцийн утга, холбохын утга нь харилцан нягт шүтэн барилдсан зүйл”<sup>1</sup> гэж академич Ш.Лувсанвандан бичжээ. Энэ нь өгүүлбэрийг найруулахдаа үгийн байрлалыг сайтар бодож, утга нь тод байхаар холбох хэрэгтэй гэсэн үг юм.

Түүнчлэн М.И.Калинин “Хэрэв үгээр үнэн зөв, яруу тодорхой илэрхийлж чадаагүй бол хүний оюун ухааны дээд ололт, хамгийн гүн гүнзгий мэдлэг, хамгийн хурц тод санаа хүмүүст хүртэхгүй өнгөрнө” гэсэн байдаг. Энэ бол найруулгад эрхэмлэх зүйл даруй мөн. Найруулга зүйн шаардлага хангаагүйгээс найруулгын алдаа үүсдэг

Бид А.П.Чеховын “Дугтуйтай хүн” хэмээх өгүүллэгийг /Ш.Цэгмэд, 1983 он/ хэрхэн орчуулсан найруулгын ур маягийн талаас нь авч үзэхийг зорилоо.

Ер нь орчуулга, тэр дундаа уран сайхны орчуулга бол амаргүй, маш нарийн

---

<sup>1</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал. Хэл зохиол судлал. XXI боть. УБ.,1979.

чимхлүүр хөдөлмөр шаарддаг. Энэ үүднээс уг өгүүллэгийг орчуулж, монгол уншигчдын хүртээл болгосон нь сайшаалтай боловч найруулгын талаас илүү нягт нямбай хандах ёстой байжээ гэж бодогдоно.

I. Нэг үг болон төрөл үгийг ойр ойрхон давтсанаас найруулгын ур маяг сулардаг.

1. А на педагогических советах он просто угнетал нас своею осторожностью, мнительностью и своими чисто футлярными соображениями. Багш нарын зөвлөгөөн дээр бол өөрийн сэрэмж болгоомжлол, өөрийн дугтуй доторх зангаараа биднийг шаналгадаг билээ. /237-р талд/

2. ... когда мы вместе шли в гимназию, был скучен, бледен, и было видно, что многолюдная гимназия, в которую он шёл, была страшна, противна всему существу его, и что идти рядом со мной ему, человеку по натуре одинокому было тяжело. Өглөө бид хамт сургуульд нь очих замд түүний царай уйтгартай зэвхийрэн цайж, түүний очиж яваа олон хүн бүхий сургууль нь эрхтэн бүхэнд нь жигшүүртэй байсан нь илтэд үзэгдэж миний дэргэд явахад тийм ганцаар байдалтай хүнд их л хэцүү байдагсан./239-р талд/.

II. Үг оновчгүй сонгосноос илэрхийлэх гэсэн зорилгодоо хүрч чадахгүйд хүрдэг.

1. Вы должны с уважением относиться к властям. Та засгийн эрхлэгчдийг хүндлэх хэрэгтэй./245-р талд/ хэмээн буулгасан нь “Удирдлагадаа хүндэтгэлтэй харилцах ёстой” гэдэг санааг гаргах гэсэн бололтой. Найруулгын ийм төрлийн алдаатай жишээ хэд хэд байна. Тухайлбал: Катит на велосипеде Коволенко, а за ним Варенька, тоже на велосипеде, красная, заморенная, но весёлая, радостная. Коваленко дугуй унан, түүний хойноос Варенька мөн дугуй унан явна. Царай нь улайран зүдэрсэн боловч баяр цэнгэлтэй байв./244-р талд/. “Улайрах” гэдэг үг нь “ажилд, тоглоомонд” гэх мэт үгтэй холбогдож “махрах, мэрийх, чармайх”, хамаг санаа сэтгэлээ тавих гэсэн утгыг илтгэдэг. Мөн хол газар дугуйгаар явахад хөл нь цуцаж ядрахаас биш, зүдэрнэ гэхэд арай оновчгүй болжээ. Дээрх өгүүлбэрт “царай нь улайх”, “цуцаж ядрах” гэж оруулсан бол арай дээр баймаар. Иймд дээрх жишээ нь учир шалтгааны алдаатай өгүүлбэр болжээ.

2. А под вечер оделся потеплее, хотя на дворе стояла совсем летняя погода, и поплёлся к Коваленкам. Орой гадаа нь зуны цаг байсан боловч дулаан хувцаслаж Коваленкогийн руу майжрав/247-р/ “Поплёлся” гэдэг үгийг “маажрав” гэж оноосон нь үг сонголтын алдаа гэж үзэхээс өөр аргагүй. Үүний оронд “сажлав”, “гэлдрэв” гэх мэтийн аль нэгээр хэлбэл зүгээр байсан мэт санагдана. “Орой нь гадаа зуны цаг байсан”-гэж монгол хүн ярьж бичдэггүй.

3. Он молодой, высокий, смуглый, с громадными руками, и по лицу видно, что говорит басом. Энэ багш болбол өндөр биетэй, бор царайтай, залуувтар хүн, лут том гартай ба бүдүүн дуугаар ярих нь түүний нүүрний байдлаар мэдэгдэнэ. /239-р тал/. “Нүүрний байдлаар” гэхийн оронд “Харваас түүний гадна дүр төрхийг ажиглахад бүдүүн дуутай байх гэмээр” гэсэн санааг илэрхийлэхийг оролдсон бололтой. Тэгээд ч учир шалтгааны хувьд бүдүүн нарийн дууг хоолойны өнгөөр ялгахад нүүрний байдлаар мэдэж болмооргүй. Түүнчлэн адилтгал зүйрлэлийг буруу хэрэглэснээс уг зүйлийн утга агуулгад тохирохгүй этгээд хачин дүрслэл бий

болдог.

4. А она ужу не молодая, лет тридцати, но тоже высокая стройная, чернобровая, краснощёкая, -одним словом не девица, а мармелад. Эгч нь их залуу биш, гучаад насны, хар хөмсөг, улаан хацартай нь ер нь хүүхэн биш, амтат жимс билээ. /239-р талд/. Энэ өгүүлбэрт бүсгүй хүний гоо үзэсгэлэнг амтат жимстэй адилтгаж байгаа юм шиг боловч амтат жимс гэсэн нь найруулах ур маягийн хувьд тун зохисгүй болжээ. Түүнээс гадна эх зохиолд нь мармелад /бүржмэл чихэр/ гэсэн байна.

5. О, как звучен, как прекрасен греческий язык! – говорил он слапким выражением: Аяа грек хэл ямар сайхан аялгуутай, ямар сайхан сонсогдоно вэ! Хэмээх амттай дуугаар өгүүлж... /237-р талд/ Со сладким гэснийг “амттай” гэж шууд үгчлэн орчуулжээ. Ерөөсөө “амттай” хэмээх харьцангуй тэмдэг нэрийг идээ ундааны зүйлд тодотгох үүргээр шууд утгаар хэрэглэхээс гадна “амтат зүүд”, “амтат яриа” гэх зэргээр утга шилжүүлэн ярьж, бичдэг тохиолдол бий.

6. Для него были ясны только циркуляры и газетные статьи, в которых запрещалось что-нибудь. Тэр гагцхүү хориглосон зүйлийн тухай бус харин Беликовт аливаа хориглосон зүйл л илүү ойлгомжтой байдаг гэсэн санааг өгүүлж байгаа бололтой.

7. .... и так такая разбитная, шумная.... чуть что, так и зальётся голосистым смехом: ха, ха, ха! Бас их үймээнтэй шуугиантай ба ... сав л хийвэл ха, ха, ха гэж чанга гэгчээр инээнэ. /239-р талд/. Эмэгтэй хүний зан аалийг “яриа хөөрөөтэй”, “дуу шуутай”, “ижий ахай болсон” гэж хэлдэгээс үймээн шуугиантай гэдэггүй. Харин орон байр заасан үгтэй нийлж “үймээн шуугиантай анги, танхим, хот” гэх заргийн нийлэмж үг үүсэж болно.

8. ... Идёт Коваленко по улице, здоровый верзила, вышитой сорочке ..., в одной руке пачка книг, в другой толстая суховатая палка. Гудамжинд өндөр цэлгэр чээжтэй, нэхмэл цамцтай Коваленко нэг гартаа ном барин, нөгөө гартаа мод тулан явна. /241-р талд/.

“Өндөр цэлгэр чээж”, “гартаа тулах” гэсэн хэлбэр оновчгүй мэт. Харин ном сугавчлан, нөгөө гараараа мод тулан явна гэх нь арай дээр.

9. Всякого рода нарушения, уклонения, отступления от правил приводили его в уныние хотя казалось бы, какое ему дело? Аливаа нэгэн хууль дүрмийг зөрчсөн явдал гарвал хэдүй түүнд үл хамаарагдах авч тэрээр их гуниглан гутрах мэт билээ. /227-р талд/. Ямар нэгэн хууль дүрэм зөрчсөн явдал гарахад хэдийгээр өөрт нь огт хамаагүй боловч тэрээр ямагт сэтгэлээр унан гонсойдог гэсэн шиг санааг гаргах байсан бололтой. Монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн нөхцөлийг тийм ч түгээмэл хэрэглэдэггүй онцлогтой. Байгаль нийгмийн юм үзэгдэл, хүний нөхцөлийг тийм ч түгээмэл хэрэглэдэггүй онцлогтой. Байгаль, нийгмийн юм үзэгдэл, хүний мэдрэхүйн эрхтэнд аяндаа өртөн тусах, үйл явдлыг өөрөө хийе гэвч хүчин мөхөсдөх, бусдын давамгай хүч чадал, зүй тогтлын эрхэнд болохыг заасан нөхцөлд л /нүдэнд үзэгдэх, гарт баригдах, дайнд ялагдах, үерт автах, тоглоомд хожигдох/ хэрэглэгддэг.

10. В разрешении же и позволении скрывался для него всегда элемент сомнительный, что-то недосказанное и смутное. Харин зөвшөөрөх, үл зөвшөөрөх зүйлүүд бол түүнд нэг л бүдэг татгалзаатай, хэлж төгсөөгүй зүйл мэт санагдана. /237-р талд/. Дээрх онцолсон үг хэллэгийг төдийлөн дүйлгээгүй орчуулсан байна.

Уг нь ямар нэгэн хууль дүрмийн цаана эргэлзээтэй, тодорхой бус, бүрхэг, дутуу дулимаг зүйл байгаа юм шиг түүнд санагддаг хэмээх утгыг илэрхийлэх гэсэн бололтой.

III. Монгол хэлний үг бүтэх ёс, үгийн хэлбэржилт, хэл зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс хэл зүйн найруулгын алдаа үүсдэг.

1. У Ивана Ивановыча была довольно странная, двойная фамилия-Чимша Гималайский ... и его по всей губернии звали просто по имени и отчеству. Малын эмч бол Чимша-Гималайский хэмээх хачин хос нэртэй боловч мужийн олон хүмүүс түүнийг зөвхөн Иван Иванович гэж дуудна. /239-р талд/. Үүнийг “Хачин нэртэй Чимша-Гималайскийг мужийнхны олонх нь Иван Иванович гэнэ” гэж орчуулсан бол арай дээр болох мэт. Мөн “бол” гэдэг үг илүүдсэнээс гадна олны утгыг “олон хүмүүс” гэж давхар илэрхийлсэн нь зохисгүй болжээ. Монгол хэлэнд “татгалзаатай” гэсэн үг байдаггүй.

2. Мөн 237-р талд буй “ямар нэгэн сурагчдын тухай цуурхал яриа гаргах...” гэсэн жишээнд “ямар нэгэн” гэсэн ялгах төлөөний үгийг олон тооны нөхцөлтэй жинхэнэ нэрэнд угсруулж холбосон нь хэл зүйн хувьд алдаатай болсон бөгөөд “ямар нэгэн” /хэн нэгэн”/ сурагч гэж буулгасан бол зүгээр байжээ.

3. Би бас танд хэлэх зүйл хэд хэд байна. /247-р талд/ гэсэн өгүүлбэрт “би” гэдэг I биеийн төлөөний үгийг өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлж “Над хэлэх зүйл байна”, “Би танд... хэлмээр байна” гэж ч орчуулж болмоор...

IV. Шаардлагатай илүү үг нуршсанаас чухам юуны тухай өгүүлж байгааг ойлгоход түвэгтэй болдог. Ийм алдаа хэлний хэмнэлтийн зарчмыг зөрчсөнөөс үүсдэг. Аль ч хэлэнд товчлох ёс, заримдаг ба нэрлэсэн өгүүлбэр, төлөөний үг зэргийг хэрэглэдэг нь хэлний хэмнэлтийн зарчмын тодорхой илрэл мөн.

1. Учитель же гимназий Буркин каждое лето гостил у графов П... и в этой местности давно уже был своим человеком. Буркин нь П... гүнгийн дунд зун цаг бүр айлчлах учир хэдүй нь эндхийн хүн мэт болжээ. /236-р талд/. Энд зун бүр гэхэд л ойлгомжтой юм.

2. Тэр хоёр элдвийн түүх ярихын сацуу ахлагчийн эхнэр Мавра гэгч ухаантай, эрүүл чийрэг эм боловч өөрийн тосгоноос хол гараагүй, хот, төмөр зам зэргийг үзээгүй сүүлийн арваад жилд гэртээ пийшингийн дэргэд сууж, гагцхүү шөнө болоход гудамнаа гардаг гэнэ хэмээн хэлэлцэж байснаа Буркин өгүүллүүн.... /236-р талд/. Энэ жишээнд “өөрийн” хэмээх ялгах төлөөний үг, “жил” гэсэн цагийн нэрд залгасан өгөх оршихын тийн ялгалын –“д” нөхцөл, “болоход” гэсэн үйл үг тус тус илүүджээ. Түүнчлэн “гэх”, “хэлэлцэх” гэдэг нь “хэлэх ярих” гэсэн адилхан утгыг илтгэдэг байхад гурвууланг нь угсруулан хэрэглэх шаардлагагүй.

Бас хоёрдугаар ангийн сурагч Петров, дөрөвдүгээр ангийн сурагч Егоров нарын хувь заяаг хэрхэн шийдэж байгааг дүрслэхдээ эхлээд сахилга батын хариуцлага тооцож дараа нь сургуулиас хөөсөн гэдэг санааг хэтэрхий нуршсаныг дараах өгүүлбэрээс ажиглаж болно. Он давил на всех, и мы уступали, сбавляли Петрову и Егорову балл по поведению, сажали их под арест и в конец концов исключали и Петрову и Егорову. Петров Егоров хоёрын сахилга батын үнэллээс хасуулж,

шоронд суулгаад бүр сүүл сүүлд нь Петров, Егоров хоёуланг хөөсөн билээ. /237-р талд/ гэсэн өгүүлбэрт хэний тухай өгүүлж байгаа нь тодорхой байсаар атал үйлийн эзнийг дахин дурдах хэрэггүй, зайлшгүй шаардлагатай бол “тэд” хэмээх III биеийн төлөөний үгийг сонгох боломжтой байсан.

3. А то, что мы проводим всю жизнь среди бездельников, сутяг, глупых праздных женщин говорим и слушаем разный вздор-разве это не фуляр? Бас бүх насыг ажил хийхгүй хүмүүс тэнэг гоёмсог хүүхэн авгай нарын дунд өнгөрүүлж жигшмээр юмсыг ярих буюу сонсож байх нь бас л дугтуй биш үү? /247-р талд/. Үгийг буруу байрлуулах нь хэл зүйн алдаа бөгөөд дээрх жишээнд “авгай хүүхэд”, “авгай хүүхэн” “хүүхэн” гэж ярьж бичдэг. Мөн ... өнгөрүүлж.. ярих буюу сонсож байх нь бас л дугтуй биш үү? гэж найруулсан нь учир зүйн хувьд алдаатай байна.

V. Ярьж бичиж буй зүйлдээ үгийн өнгө аясыг тохируулах нь найруулга зүйн чухал шаардлагын нэг байдаг. Ганц үгсийн өнгө аяс тохирохгүйгээс ийм алдаа гарч болно.

Людей, одиноких по натуре, которые, как-отшельник или улитка, стараются уйти в свою скорлупу, на этом свете не мало. Дун хорхой мэт хальсанд ороод суудаг ганцаар байдалтай хүмүүс энэ ертөнц дээр цөөнгүй /236-р талд/. Энд тэр хүнийг ганцаардмал зожиг гэж хэлсэн санаа гарч байгаа, харин “хальсанд ороод суудаг” гэсэн хэллэг нь ойлгомжгүй, этгээд хачин санагдана. Чой.Лувсанжав багшийн “Орос монгол өвөрмөц хэлцийн толь”-д “уйти в скорлупу” гэсэн хэллэгийг “довоо шарлуулах, худгийн мэлхий шиг байх, тэндээ шигдэх, явцуурах, хар амиа хаацайлах, аминдаа арчтай бай” гэх зэргээр орчуулжээ. Иймд “хальсанд ороод суух” гэхийн оронд дээрх хэллэгийн аль нэгээр орчуулах нь оновчтой байжээ.

Түүнчлэн орчуулгын зарим хэсэгт юуны тухай өгүүлж байгаа нь мэдэгдэхээргүй өгүүлбэр ч тохиолдож байна. Жишээ нь “Беликов мэтийн тийм хүмүүсийг оршуулах гэдэг их төлөв тааламжгүй хэрэг шүү. Оршуулгын газраас буцаж ирэхэд бидний нүүр царай ердийн дорой мэт байсан нь бага насандаа томчууд гадагш бид бүрэн эрхтэйгээр цэцэрлэг дотуур нэг хоёр цаг гүйж явдаг шиг тааламжтай сэтгэлийг ил гаргахыг хэн ч хүссэнгүй”. /247-248-р талд/.

Бид уг зохиолын орчуулгад гарсан улирах цагт эдгэшгүй шавхагдашгүй ер бусын цэнэгтэй байдаг. Иймд уг бүтээлийг дахин дахин орчуулдаг нь тэрхүү шавхагдашгүй чанарыг нь илтгэн харуулж байгаа хэрэг. Чухамхүү орчуулгын ачаар сонгодог бүтээл туурвил мөнхөрдөг бөгөөд тэр ч байтугай уг зохиол бичигдсэн эх хэл нь мөхсөн хойно ч орчуулга нь үлдэж өнөөг хүрсэн жишээ соёлын түүхэнд олон бий. Орчуулагч бол зохиогчийн өрсөлдөгч гэж ярилцдаг хэмээн эрдэмтэн зохиолч Э.Оюун гуайн бичсэнийг анхаарууштай юм.

## НОМ ЗҮЙ

1. Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүй. УБ., 2009.
2. А.П.Чеховын түүвэр зохиол. УБ., 1983.
3. Ш.Лувсанвандан. “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал.
4. Хэл зохиол судлал. XXI. УБ., 1986.
5. Орчуулах эрдэм. УБ., 1976.

### **РЕЗЮМЕ**

В данной статье, опираясь на материалы перевода повестей А.П.Чехова.

“Человек в футляре” сделал попытку вкратце рассмотреть некоторые стилистические ошибки на конкретных примерах.

Из проанализированных примеров видно, что при переводе нужно уделять понятиям формы и содержания языков, очень важно вникнуть в оттенки значений, оттенки ассоциаций.